

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2004 оны 10 дугаар сарын
21-ны өдөр

Дугаар 403/356

Улаанбаатар хот.

Журам батлах тухай

ТУШААХ нь:

1. Шинэчлэн боловсруулсан 'Иргэний агаарын хөлгийн онцгой үүргийн нислэгийн журам'-ыг хавсралтын дагуу баталсугай.
2. Иргэний агаарын хөлгийн онцгой үүргийн нислэгийн журам шинээр батлагдсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын 2001 оны 426/715 тоот хамтарсан тушаалаар батлагдсан Тусгай үүргийн нислэгийн журам'-ыг хүчингүйд тооцсугай.



ИНЕГ-ын дарга, ТТХГ-ын даргын
2004 оны хамтарсан 4031.....
түүт тушаалын хавсралт.

ИРГЭНИЙ АГААРЫН ХӨЛГИЙН
ОНЦГОЙ ҮҮРГИЙН НИСЛЭГИЙН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Монгол Улсад төрийн айлчлал хийж байгаа, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн дагуу тусгай хамгаалалтад авагдсан гадаад орны төр, засгийн тэргүүн, өндөр хэмжээний зочдод үйлчлэх зорилгоор үйлдэж буй нислэгийг онцгой үүргийн нислэгт хамааруулна.

1.2. Онцгой үүргийн нислэгийн үйл ажиллагаанд энэ журмаас гадна Иргэний нисэхийн тухай хууль, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журмыг мөрдөнө.

Хоёр. Онцгой үүргийн нислэгийн захиалга

2.1. Ерөнхийлөгчийн болон УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар /цаашид Захиалагч гэх/ нь онцгой үүргийн нислэгийн захиалгыг орон нутгийн агаарын шугамд нислэг эхлэхээс 7 хоног, олон улсын агаарын шугамд нислэг эхлэхээс 14 хоногийн өмнө Тээвэрлэгчид хүргүүлж, Төрийн тусгай хамгаалалтын газар /цаашид ТТХГ гэх/-т мэдэгдэнэ.

2.2. Тээвэрлэгч нь онцгой үүргийн нислэгийн захиалгыг хүлээн авмагц агаарын хөлгийг онцгой үүргийн нислэгт бэлтгэх комиссыг томилно.

2.3. Онцгой үүргийн нислэгтэй холбогдсон төлбөр тооцоо болон аж ахуйн бусад асуудлыг нислэгийг Захиалагч болон Гүйцэтгэгч /Тээвэрлэгч/ талуудын хоорондын гэрээгээр зохицуулна.

Гурав. Онцгой үүргийн агаарын хөлгийг нислэгт бэлтгэх

3.1. Тээвэрлэгч, эсхүл ТТХГ-аас шаардлагатай гэж үзвэл онцгой үүргийн нислэг үйлдэх агаарын хөлгөөр шалгах нислэг үйлдэнэ.

3.2. Тээвэрлэгчийн томилсон комисс агаарын хөлгийг онцгой үүргийн нислэгт бэлтгэх ажиллагаа дууссаны дараа тухайн агаарын хөлгийн техникийн бэлэн байдлыг үнэлсэн актыг онцгой үүргийн нислэг эхлэхийн өмнө Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид ИНЕГ гэх/ болон ТТХГ-т тус тус хүргүүлнэ.

3.3. ИНЕГ-аас агаарын хөлгийн нислэг, техникийн бэлэн байдлыг үнэлсэн акттай танилцаж баталгаажуулан ТТХГ-т мэдэгдэнэ.

3.4. Онцгой үүргийн агаарын хөлгийн болон бусад зүйл /зорчигчийн танхимын ариун цэвэр, ариун цэврийн болон ундны ус, хүнсний зүйл, эмийн сан г.м/-ийн эрүүл ахуйн аюулгүй байдлыг Тээвэрлэгч хариуцах бөгөөд үүнд ТТХГ хяналт тавина.

3.5. Онцгой үүргийн агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх ажлыг Төрийн тусгай хамгаалалтын ажилтны шууд хяналтын дор гүйцэтгэх бөгөөд шатахууны сорьцыг лацдан тухайн нислэг дуусах хүртэл ТТХГ-т хадгална.

3.6. Орон нутагт нислэг үйлдэх үед шатахуунаар цэнэглэх ажлыг Төрийн тусгай хамгаалалтын ажилтны хяналтанд гүйцэтгэж, сорьцыг лацдан тухайн орон нутаг дахь ТЕГ-ын харъяа газар, хэлтэст хадгалуулна.

Дөрөв. Онцгой үүргийн нислэг үйлдэх агаарын хөлөг, нисэх баг

4.1. Онцгой үүргийн нислэг үйлдэх иргэний агаарын хөлөг нь Иргэний нисэхийн ерөнхий газар /ИНЕГ/-аас олгосон хүчин төгөлдөр Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй, хоёроос доошгүй хөдөлгүүртэй байна.

4.2. Тээвэрлэгч нь онцгой үүргийн нислэгт оролцох үндсэн болон нөөц нисэх багийн гишүүдийн нэрсийг гаргаж ИНЕГ-аар баталгаажуулан ТТХГ-т мэдэгдэж зөвшөөрөл авна. Онцгой үүргийн нислэгийн үүрэг гүйцэтгэх нисэх багийн бүрэлдэхүүнд багш нисэгчийг оруулж болно.

4.3. Гадаад улс руу үйлдэх онцгой үүргийн нислэгт, агаарын хөлгийг хөндлөнгийн халдлага, хууль бус үйлдлээс хамгаалах зорилгоор томилогдсон Төрийн тусгай хамгаалалтын ажилтны зардлыг Тээвэрлэгч хариуцна.

4.4. Тээвэрлэгч нь асуудлыг газар дээр нь шуурхай зохицуулах зорилгоор онцгой үүргийн нислэг үйлдэх багийн бүрэлдэхүүнд өөрийн байгууллагын удирдах ажилтнуудаас томилж болох ба энэ тухайгаа ТТХГ-т урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авна.

4.5. Онцгой үүргийн нислэг үйлдэх агаарын хөлөг нь төрийн тусгай хамгаалалтын бүсэд тооцогдоно.

4.6. Үндсэн баазаас бусад газарт нислэг үйлдэж буй үед ТТХГ-ын ажилтан шаардлагатай гэж үзвэл нисэх багийн гишүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж болно.

4.7. Онцгой үүргийн нислэгт томилогдсон ТТХ-ын ажилтан нь онцгой нөхцөл байдал /осол, аваар/-ын үед агаарын хөлгийн багийн гишүүдийн үүрэгт ажилд оролцохгүй.

4.8. Тээвэрлэгч нь Иргэний нисэхийн хууль, дүрмийг чанд мөрдөж, Онцгой үүргийн нислэгийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

Тав. Онцгой үүргийн нислэгийн зорчигч, ачаа тээш

5.1. Тээвэрлэгч нь нислэгийн аюулгүй ажиллагааг хангах шаардлагын үүднээс, онцгой үүргийн нислэгийн зорчигч, ачаа, тээшний тоо хэмжээг нислэгийн хязгаарлалтаас хэтрүүлэхгүй байх үүргийг хүлээнэ.

5.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Монгол Улсад төрийн айлчлал хийж байгаа гадаад орны төр, засгийн тэргүүнийг дагалдаж буй онцгой үүргийн нислэгийн бусад зорчигчид, тэдгээрийн гар тээш, тээш, ачааг тогтоосон журмын дагуу аюулгүй байдлын үзлэгт хамруулна. Энэ үйл ажиллагаанд ТТХГ-ын ажилтан хяналт тавина.

5.3. Онцгой үүргийн нислэг үйлдэж буй агаарын хөлөгт завсрын буудлаас төлөвлөгдөөгүй зорчигч, ачаа, тээш авах асуудлыг ТТХГ-ийн ажилтан нисэх багийн даргатай зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэж, аюулгүй байдлын үзлэгийг ТТХГ-ийн ажилтан хариуцан хийнэ.

5.4. Нислэгийн аюулгүй ажиллагааг хангах шаардлагын үүднээс, онцгой үүргийн нислэгийн үед агаарын хөлгийн даргын тавьсан шаардлагыг агаарын хөлөгт байгаа бүх хүмүүс биелүүлнэ.

Зургаа. Онцгой үүргийн агаарын хөлгийн хамгаалалт

6.1. Онцгой үүргийн нислэгт бэлтгэгдсэн агаарын хөлгийг төрийн тусгай хамгаалалтад авна.

6.2. ТТХГ-аас онцгой үүргийн агаарын хөлгийн хамгаалалтыг нийслэл хотод болон орон нутагт зохион байгуулахдаа аяллын онцлог, цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр хүн хүч, зэвсэг техникийн оролцоог тооцож зохицуулна.

6.3. Онцгой үүргийн агаарын хөлгийг гадаад улсад хамгаалах ажлыг тухайн орны төрийн хамгаалалтын байгууллагатай хамтран зохион байгуулна.

6.4. Онцгой үүргийн нислэгийн үеийн агаарын хөлгийн хамгаалалт :

1/ Онцгой үүргийн нислэг үйлдэх талаар ТТХГ-аас БХЯ-ны Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлалд мэдэгдэнэ. Монгол Улсын агаарын зайд БХЯ-ны Агаарын довтолгооноос хамгаалах цэрэг радиолокацийн хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл агаарын довтолгооноос хамгаалах цэргийн хүч хэрэгслэлээр хамгаална;

2/ гадаад улсын нутаг дэвсгэр дээр болон далай тэнгис дээгүүрх нислэгийн үеийн хамгаалалтыг олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу зохицуулна.

6.5. Онцгой үүргийн агаарын хөлөгт үйлчилгээний болон бусад ажлын шаардлагаар нэвтрэх хүмүүс, Хилийн цэрэг, гаалийн ажилтнууд тусгай хамгаалалтын бүсэд ТТХГ-ын зөвшөөрөлтэйгээр нэвтэрнэ.

6.6. Тусгай хамгаалалтын бүс, онцгой үүргийн нислэг үйлдэх агаарын хөлгийн хамгаалалт болон харуулын үйл ажиллагааг шалгаж зааварлах ажлыг ТТХГ хариуцна.

6.7. ТТХГ-аас томилогдсон харуулын хэсэг нь агаарын хөлгийн гадна байрлах бөгөөд хамгаалалтын үйл ажиллагаандаа ТТХГ-ын холбогдох заавар, журмыг мөрдөнө.

6.8. Тусгай хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүй нэвтэрсэн буюу нэвтрэхийг завдсан этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Долоо. Онцгой үүргийн нислэгийн хангалт

7.1. Онцгой үүргийн нислэг үйлдэх аэродромууд, тэдгээрийн навигацийн болон бусад тоноглолын бэлэн байдал, цаг уурын болон нислэгийн бусад мэдээллээр хангах ажил иргэний нисэхийн холбогдох дүрэм, журмаар зохицуулагдана.

7.2. Захиалагч зөвшөөрөгдсөн аэродромоос өөр газарт буух захиалга өгсөн тохиолдолд талбай сонгох, бэлтгэхтэй холбогдон гарах зардлыг Захиалагч хариуцна.

7.3. Зөвшөөрөгдсөн аэродромоос өөр газар талбай сонгож буух тохиолдолд Тээвэрлэгч талбай сонгосон тухай актыг үйлдэж ИНЕГ-т ирүүлнэ.

7.4. Гадаад улсад онцгой үүргийн нислэг үйлдэх үед үүсэх асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох бусад эрхийн актын дагуу зохицуулна.

7.5. Онцгой үүргийн нислэг үйлдэж буй нутаг дэвсгэрт цэрэг дайны болон байгалийн гамшиг, гоц халдварт өвчин зэрэг нөхцөл байдал үүсэн тохиолдолд нислэгийн үйлчилгээнд оролцогч талууд олон улсын гэрээ, Монгол Улсын Иргэний хамгаалалтын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.

Найм. Онцгой үүргийн нислэгийн хүнсний аюулгүй байдлыг хангах

8.1. Тээвэрлэгч нь онцгой үүргийн нислэгийн үед хэрэглэх ахуйн хэрэгцээний ус болон хүнсний бүтээгдэхүүнд лабораторийн шинжилгээ хийлгэсэн байна.

8.2. Онцгой үүргийн нислэгийн хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын баталгаажилтад ТТХГ-ын Эрүүл мэндийн хяналтын улсын байцаагч хяналт тавина.

8.3. Гадаад улсад болон орон нутагт онцгой үүргийн нислэг үйлдэж буй агаарын хөлөгт ахуйн хэрэгцээний ус, хүнсний бүтээгдэхүүнээр хангалт хийх ажиллагаанд ТТХГ-ын ажилтан хяналт тавина.

Ес. Онцгой үүргийн нислэгийг дууссанд тооцох

Онцгой үүргийн нислэгийн Захиалагч аяллын зорилго биелсэн тухай Тээвэрлэгч болон бусад байгууллагад ТТХГ-аар дамжуулан албан ёсоор мэдэгдсэн үеэс онцгой үүргийн нислэгийг дууссанд тооцно.

-----х-----